



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/326

Чингис хот

Үнэлгээний хороо байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжих “Шинэ суурьшлын бүсэд цахилгаан дамжуулах агаарын шугам татах (Хэрлэн сум)”, “Сумын төвийн гэр хорооллын гэрэлтүүлэг (Хэрлэн сум)”, “Хуучин Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байрны урд талын 30 айлыг дулаан цэвэр усны шугамд холбох (Хэрлэн сум)” ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Ц.Чогсомжав	Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	И.Баасанжав	Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Б.Сандагдорж	Багануур зүүн өмнөд бүсийн Цахилгаан түгээх сүлжээ Төрийн өмчит хувьцаат компанийн харъяа Хэнтий цахилгаан түгээх сүлжээ салбарын ерөнхий инженер
	Б.Цэрэнчимэд	Төрийн бус байгууллагын төлөөлөл
	Д.Оюун	Төрийн бус байгууллагын төлөөлөл

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Ц.Чогсомжав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

221011711